

Агуулга

Нэг. Танилцуулга	2
Хоёр. Судалгааны ажлын зорилго	2
Гурав. Судалгааны ажлын аргачлал	2
Дөрөв. Дээжлэлт хийсэн аргачлал	3
4.1. Байгалийн усны химийн найрлага, түүний тухай ойлголт	3
4.1.1. Усны дээжинд химийн ерөнхий шинжилгээ хийх арга зүй	5
4.1.2. Ундны усны чанар	7
4.2. Лабораторийн шинжилгээний аргачлал болон нарийвчлал	8
Тав. Лабораторийн шинжилгээний дүн	8
5.1. Лабораторийн шинжилгээний үр дүнд хийсэн чанарын шинжилгээ	8
Зургаа. Ус хангамжийн цэгүүдийн эрүүл ахуйн өнөөгийн байдал	25
Долоо. Судалгааны ажлын үр дүн	25
Найм. Цаашид хэрэгжүүлэх шаардлагатай ажлын зөвлөмж	26
Хавсралт	28

Нэг. Танилцуулга

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих” (УУДБХОД) төслийн 3-р бүрэлдэхүүн хэсэг нь “Газрын доорх усны менежмент, мэдээллийн нэгж” (ГДУММН) болон говийн бүсийн 3 сав газрын захиргаад болох: Умард говийн гүвээт-Халхын дундад талын СГЗ, Галба-Өөш-Долоодын СГЗ, Алтайн Өвөр говийн СГЗ-д хамаардаг.

Уг төслийн хүрээнд говийн бүсийн сумдын төвүүд болон суурин газруудын ундны усны чанарын судалгааны төслийг хэрэгжүүлж байна. Судалгааны талбайд хамаарах сумын төвүүд болон суурин газруудын унд ахуйд ашиглаж буй худгуудыг хамруулсан.

Судалгааны ажлын хээрийн хэмжилт болон дээжлэлтийн ажилд сав газрын захиргаадын мэргэжилтнүүд болон аймаг, сумдын байгаль орчны мэргэжилтнүүд хамтран ажилласан бөгөөд ерөнхий болон хүнд элементийн шинжилгээг Монгол улсад итгэмжлэгдсэн “Эс Жи Эс Монгол” лабораторид шинжлүүлсэн.

Хоёр. Судалгааны ажлын зорилго

Улсын Их Хурлаас 2010 оны 24-р тогтоолоор “Ус” үндэсний хөтөлбөр, 2013 онд Монгол Улсын Засгийн Газрын 389-р тогтоолд заасны дагуу “Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүлж байна. Энэхүү ажлын хүрээнд говийн бүсийн сумын төвүүдийн унд-ахуйн усны чанарын судалгааг хэрэгжүүлснээр говийн бүсийн сумын төвүүдийн хүн амын унд ахуйд хэрэглэж буй усны чанар найрлагыг тогтоож, Монгол улсын унд ахуйн усны стандарт “MNS 0900-2005”-д үл нийцэх элементүүдийг шүүх, цэнгэгжүүлэх, зөөлрүүлэхэд зохимжтой шүүлтүүрийг тодорхойлох, түүний ашиглалтын горим болон хугацааны талаар зөвлөмж боловсруулахад уг ажлын гол зорилго оршино.

Мөн цаашид уг судалгааны ажлыг үргэлжлүүлэн унд ахуйн усны стандартад тохирохгүй ус хэрэглэж буй сумын төвүүдийг хамруулан улирлын давтамжтай дээжлэлт, шинжилгээ хийж, газрын доорх усны чанар найрлагыг геологи-гидрогеологийн нөхцөл, тэжээгдлийн муж, суурьшлын бүс зэргээс хэрхэн хамааралтайг тогтоох зорилготой.

Гурав. Судалгааны ажлын аргачлал

Уг судалгааны ажлын дагуу Хэнтий аймгийн сумдын төвийн унд ахуйн усны чанарыг тодорхойлохын тулд газрын доорх усны дээжлэлтийг Умард говийн гүвээт-Халхын дундад талын СГЗ-ны мэргэжилтнүүд болон аймаг, сумдын байгаль орчны мэргэжилтнүүд хамтран гүйцэтгэсэн.

3.1. Дээжлэлт хийсэн аргачлал

Газрын доорх усны дээжлэлт хийхэд дараах шинж чанаруудыг харгалзав. Үүнд:

- Худгийн байршил,
- Худгийн гүн,
- Геологийн үе давхарга,

Хээрийн ажлаар нийт 10 худагт ерөнхий ба хүнд металлын шинжилгээнд зориулан газрын доорх усны дээжлэлт хийсэн.

Газрын доорх усны дээжлэлтийг явуулахын тулд тухайн уст давхаргыг нээсэн уст цэгт хуримтлагдсан усны эзэлхүүнийг 3 дахин шавхан зайлуулсны дараа дээж авах шаардлагатай байдаг. Энэ нь худагт хуримтлагдсан усанд ууссан хүчил төрөгч эсвэл худгийг тоногдсон материалаас газрын доорх усны чанар найрлагад үзүүлж буй нөлөөллийг авч буй дээжинд хамгийн бага байлгах, уст давхаргад агуулагдах газрын доорх

усны бодит шинж чанарыг шинжлэхэд ач холбогдолтой юм. Байнга ашиглаж буй худгаас газрын доорх усны дээжлэлтийг шууд авч болно.

Дөрөв. Дээжлэлт хийсэн аргачлал

Газрын доорх усны дээжлэлт хийхэд дараах шинж чанаруудыг харгалзав. Үүнд:

- Уст цэгийн тодорхойлолт - солбицол, өндөршил, усны тогтсон түвшин, ундарга, түвшин бууралт зэргийг тодорхойлох
- Ундны ус хангамжийн худгийн эрүүл ахуй - тухайн худаг орчмын эрүүл ахуйн талаар тодорхойлох, газрын доорх уст давхаргыг бохирдуулах магадлалтай эх үүсвэрийг тодорхойлох,
- Усны дээжлэлтийн хуванцар саванд авах бөгөөд савалгаан дахь агаарын бөмбөлөг хамгийн бага байхаар савлах зэрэг шаардлагын дагуу дээжлэлтийн ажлыг гүйцэтгэсэн.

Хээрийн ажлаар нийт 10 худагт ерөнхий ба хүнд металлын шинжилгээнд зориулан газрын доорх усны дээжлэлт хийсэн.

Хээрийн ажлын эхэнд тухайн уст цэгүүдийн гэрэл зургийг авч баталгаажуулсан. Газарзүйн байршил тодорхойлогч GPS багажны тохиргоог Монгол улсын Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоо”-г үндэслэн WGS 84-өөр хийж, байр зүйн солбицлыг объект бүрт тодорхойлсон.

Хээрийн нөхцөлд усны чанарын зарим үзүүлэлт болох усны орчин, цахилгаан дамжуулах чадвар, температур зэргийг рН метр болон электрон тодорхойлогч багажаар тодорхойлж, хээрийн маягт-д тэмдэглэсэн.



Зураг 1

1.усны түвшин хэмжигч, 2. Байршил тогтоогч, 3. рН метер, 4. Зургийн аппарат

4.1. Байгалийн усны химийн найрлага, түүний тухай ойлголт

Байгалийн усыг химийн найрлагаар нь 5 бүлэгт хуваана .

1. Гол ионууд (Cl^- , SO_4^{2-} , HCO_3^- , CO_3^{2-} , Na^+ , K^+ , Ca^{2+} , Mg^{2+})
2. Ууссан хий (O_2 , N_2 , CO_2 , H_2S)
3. Биогенийн элементүүд(азот , фосфор , цахиурын нэгдэлүүд)
4. Микроэлементүүд (дээрхээс бусад үлдсэн химийн бүх элементүүд)
5. Органик бодисууд .

Усны найрлагыг бүрдүүлэгч эх үүсвэр. Гадаргын усны найрлага нь 1-рт газрын гүнээс мантийн давхрааны дегазацийн процессоор ялгарч байгаа хий. 2-рт усны газрын

гадаргын бялхмал чулуулгуудтай харилцан үйлчлэх үйлчлэлийн дүнд үүссэн химийн бүтээгдэхүүн зэргээс бүрдэнэ .

Анион, катионуудын гарал үүсэл. Усанд анионы найрлага үүсэх явц нь гол төлөв мантийн хий ялгаруулах процессоор ялгарч буй хийтэй холбоотой. харин усанд катионууд нь бялхмал чулуулгууд устай харилцан үйлчилсний дүнд үүснэ. Өөрөөр хэлбэл чулуулгуудын усны угаагдлаар болон чулуулгуудын задралаар гадаргуугийн ус катионуудаар баялаг болно .

Байгалийн усны химийн найрлага бүрэлдэн тогтоход нөлөөлөх хүчин зүйлсүүд . Энэхүү хүчин зүйлсүүдийг 2 бүлэгт хуваана .

1-рбүлэгт нь шууд хүчин зүйлсүүд . Үүнд : уулын чулуулгууд , эрдэсүүд , хөрс, амьд организм, хүний үйл ажиллагаа

2-р бүлэгт шууд бус хүчин зүйлсүүд . Үүнд : цаг уур, уур амьсгал, усан сүлжээ, ургамал, амьтан, гидрогеологийн ба гидродинамик нөхцлүүд орно.

Байгалийн усны эрдэсжилтийг үүсгэгч уулын чулуулаг болон эрдсийн нөлөөг

А. Бялхмал , магнийн чулуулгийн

Б. Янз бүрийн тунамал чулуулгийн

В. Шохойн чулуу, мергеля, доломит, гипс, чулуун давсны гэж хуваана . Эдгээр нөлөө нь харилцан адилгүй байна. Эдгээр чулуулгуудыг анх эрдэмтэн А.Д .Кушман , П . Хубарт нар 1908 онд илрүүлж , цаашид усанд усах үйл явцыг нь К.В. Корренс , В. Энгельгарут нар 1838 онд судалжээ. Жижиглэж нунтагласан дурын бялхмал чулуулгыг нэрсэн усанд хийгээд үүссэн уусмалд анализ хийсэн ба энд явагдах урвалыг нь хөнгөнцагааны силикатын гидролиз, явагдах процессыг нь чулуулгийн шүтлэгжих үзэгдэл гэж нэрлэсэн. энэхүү катион солилцооны урвалын үед силикатуудын усах хүхэр болон металлуудын исэлдэх үзэгдлүүд дагалдах ба хөнгөнцагааны талст торын бүтэц өөрчлөгдөнө.

Усанд ууссан хийнүүд. Ус нь оршиж буй байгалийн нөхцлөөсөө хамаарч чанарын ба тооны найрлагань өөр өөр байдаг. Эдгээр хийнүүд нь

А.атмосферээс үүсэлтэй хийнүүд (“ N_2, O_2, Ar) бусад идвэхгүй хийнүүд, хүнд нүүрс устөрөгчид CO

Б. Биохимийн процессоор үүссэн хийнүүд (CO_2 бусад хүнд нүүрстөрөгчид H_2S, N_2, H_2)

В. өндөр даралт ба температурын нөлөөгөөр газрын гадаргын гүн дэх уулын чулуулгын метаморфизм ба мантийн хий ялгаруулах процессоор ($CO_2, CO, H_2S, H_2, CH_4, NH_3, HCl$ бусад галлогент устөрөгчид) зэрэг хийнүүд байна .

Атмосферээс үүсэлтэй болон биохимийн процессоор үүссэн хийнүүд нь ихэвчлэн гадаргын ба гүний усанд, өндөр даралт, температурын нөлөөгөөр газрын гүнд уулын чулуулагыг метаморфизм ба мантийн хий ялгаруулах процессоор үүссэн хийнүүд нь гүний усанд тус тус агуулна. Гадаргын усанд ихэвчлэн CO_2, O_2 , гүний усанд H_2S, CH_4 , зэрэг хийнүүд агуулагдана.

Байгалийн усны органик бодис .Усанд органик бодис үүсэх үйл явц 2 янз байна. Усанд гаднаас цутгаж буй усаар дамжин ирэх, эсвэл өөрт нь органик бодис шинээр үүсч болно. ер нь усанд органик бодис нь ургамал, ойн түймрийн үлдэгдэл, хөрсний угаагдлаар

үүсч буй ялзмагийн бодис, ахуйн хэрэгцээний бохир ус зэргийн нөлөөнөөс болдог . Байгалийн усны органик бодисын агуулга 1.0-50 мг/дм хүрдэг байна

Органик бодисыг тодорхойлох нь 1 литр усан дахь органик бодисыг исэлдүүлэхэд зарцуулагдаж байгаа хүчилтөрөгчийн тоо хэмжээг тодорхойлох дээр үндэслэнэ . Тодорхойлолтонд ашиглаж буй исэлдүүлэгчээс нь хамааруулан перманганатын ба бихроматын исэлдэх чанарыг ашигладаг. Перманганатын исэлдэх чанар нь усны органик бодисын агуулгыг тодорхойлох боломж олгодог төдийгүй тухайн усны бохирдолтын талаар дүгнэлтийг хийх боломжийг өгдөг.

4.1.1. Усны дээжинд химийн ерөнхий шинжилгээ хийх арга зүй

Байгалийн уснаас дээж авах үед усны болон агаарын температурыг хэмжинэ . Мөн усны дээжинд ууссан хийнүүд (CO_2 , O_2), pH, HCO_3 , CO_3 зэргийг аль болох хурдан хугацаанд боломжтой үед газар дээр нь тодорхойлох шаардлагатай байдаг . Мөн усны дээжинд өнгө , үнэр, амт, тунгалаг чанар, булингар зэрэг физикийн шинж чанаруудыг тодорхойлно .

Усны амт: нь байгалиас гаралтай зарим бодисын буюу эсвэл урсацын замд ууссан бодисуудын нөлөөнөөс бий болно . Хөрсний доорхи ус нь, түүнд ууссан төмөр , манган, магни, натри, кали, хлор, карбонат, органик бодисуудаас үүссэн өвөрмөц амттай болдог. Амтын шинжийг зөвхөн ундны усанд шууд амтлах аргаар тодорхойлж болно . Байгалийн усанд дөрвөн үндсэн амт байдаг. Үүнд: давслаг, чихэрлэг, гашуувтар, исгэлэн мөн зарим усанд шүлтлэг , металлын амт байдаг. Амтлаг шинжийг тодорхойлох явдал нь шинжлэгч хүний ажлын дадлага туршлага амтлахын чадвараас шалтгаална . Амтыг хэд хэдэн хүн зэрэг амталж үзэх нь алдаагүй мэдэх боломжтой. Ундны усанд амтыг тодорхойлохдоо уг усанд бактериологийн шинжилгээ хийж хортой чанарын хольцгүй , хордуулах бодисын нөлөө байхгүй гэсэн усанд хийх ёстой. Амтыг тодорхойлохдоо тасалгааны буюу 4 с-ын температуртай усанд эсвэл дээжийг авч байгаа газар дээр нь хийж гүйцэтгэнэ. Амтлахын тулд амандаа 10-15 мл ус балгаж хэдэн секундын турш байлгаж, амтыг тодорхойлон мэдсэний дараа усыг залгихгүй гадагш асгана .

Усны үнэр: нь өөрийн найрлагын буюу гадны нөлөөнөөс дэгдэмхий үнэрт бодис агуулагдсанаа үүснэ. Органик бодисоор баялаг ус нь зөвхөн хүхэрт устөрөгчийн үнэртэй байдаг. Усны үнэрийг шууд үнэрлэж мэдэх ба бусад төрлийн усыг сулруулах буюу тооцооны аргаар үнэрийг нь мэдэж болно. Ундны усанд үнэрийн шинж , түүний ихсэлтийг үнэртэж тодорхойлно. Дээжийг 20-60 С –т халааж мэдэгдэж байгаа үнэрийн талаар тодорхойлон бичнэ. Үүнд: газар шорооны, ялзарсан өвс ногооны, хөгцний, муудсан болон эсвэл өмнө бичигдсэн химийн янз бүрийн бодисын үнэр буюу ургамлын төрлийн үнэр гэх мэтээр тодорхойлон бичнэ.

Усны температур: Дээжийг авах үед усны температурыг хэмжих нь шинжилгээний ажлын салшгүй хэсэг мөн . Усны температурыг хэмжихдээ нарийн хуваартай мөнгөн усны термометрийг ашиглан давталттай хэмжилт хийж гүйцэтгэх нь зүйтэй. Термометрийн хуваарийн нарийвчлал нь 0.1-0.5С байна . Гадаргуугийн усанд термометрийг шууд дүрж хэмжинэ Ус руу шууд дүрж хэмжих боломжгүй тохиолдолд дээжийг 1л –ийн саванд авч, тэр даруйд нь хэмжилтийг авна. Дээж авч байгаа үед орчны агаарын температурыг хэмжихдээ газраас 1 м –ээс доошгүй өндөр зайнд хуурай термометрээр хэмжилтийг хийнэ

Усны тунгалагшилт: Тунгалагшилт нь усны өнгө ба булингараас хамаарна. Тунгалагшилтын хэмжээг тодорхойлох хэмжигдэхүүн нь усны багнийн үеийн өндөр юм. Тэр нь тодорхой хэмжээтэй хийгдсэн үсгийн дүрсийг харж болох усны үеийн зузаан юм. Гадаргуугийн усанд дээж авч байгаа газар дээр нь мөн стандарт самбарыг ашиглан гүйцэтгэж болно. Стандарт самбараар хэмжих нь дөрвөлжин буюу дугуй хэлбэртэй

хийгдсэн цагаан самбарын нэг талын урт буюу диаметр нь 20 см байна. Самбарыг урт модонд бэхэлж түүн дээр сантиметрийн хуваарь тавина. Ус руу хийгдсэн цагаан самбар харагдахгүй болох үеийн усны гүний хэмжээгээр тодорхойлолтын хэмжилтыг авна.

Усны өнгө: Байгалийн цэвэр ус бол бараг өнгөгүй байдаг. Усны өнгө нь түүнд агуулагдах ялзмагийн бодис 3 валенттай төмрийн нэгдлийн улмаас үүсэх бөгөөд тэдгээрийн агуулагдах хэмжээ нь хөрсөн дэх геологийн нөхцөл, дээж авсан газар нутгаас шалтгаална. Усны өнгө нь усны булингар, түүнд орших бичил махбод, шавар, хүхэрт нэгдлийн нөлөөнөөс болж үүснэ. Усны өнгийг байгалийн шүүгдээгүй усанд шууд юмуу шүүсэн тунгалаг усанд тодорхойлж болох ба ус нь хөвмөл бодис ихтэй үед тодорхой хугацаагаар тавьж тунгалаг болсоны дараа тодорхойлно.

Байгалийн усны өнгийг бодит байдлаар тодорхойлох нь нилээд төвөгтэй ажил юм. зарим тохиолдолд спектро-фотометрийн аргаар тодорхойлолт хийнэ. Усны өнгийг тодорхойлох үндсэн аргын нэг бол өнгөт усны 10 см зузаан үеийг шууд харж тодорхойлно. Тунгалаг буюу шүүгдсэн дээжний өнгийг стандарт уусмал болох калийн хлороплатинат, хлорт кобальт буюу эсвэл калийн бихромат ба сульфат кобальтын уусмалын өнгөтэй харьцуулан тодорхойлно. Эдгээр аргыг гол төлөв хөрсний ялзмагийн бодис байгаагаас үүссэн шар буюу улаан хүрэн өнгөтэй усанд хэрэглэхэд тохиромжтой.

Өнгө тодорхойлох усыг хадгалахгүй ба дээж авснаас цагийн дараа тодорхойлолтыг гүйцэтгэнэ. Өнгийг харьцуулан тодорхойлохдоо цилиндрт 10 см зузаан үетэй ус хийгээд цагаан дэвсгэр дээр тавьж өдрийн тод гэрэлд дээрээс нь харж тодорч байгаа өнгө буюу өнгөний туяаны талаар тод буюу сулавтар үр дүнг бичнэ.

Усны булингар: Усанд органик болон органик бус гаралтай уусаагүй ба коллоид бодисуудаас булингар үүснэ. Газрын гадаргуугийн усанд булингар буй болох шалтгаан нь наанги шавар, цахиурын хүчил, төмөр ба хөнгөнцагааны усан исэл, органик бодис, коллоидууд, бичил организмууд болон усны жижиг амьтад юм. Хөрсний доорхи ус ихэнхдээ уусаагүй эрдсүүд, органик үүсэлтэй элдэв бодисууд, мөн янз бүрийн ус доош нэвтэрч орсноос булингартай болдог. Ундны болон гадаргуугийн усанд булингарталтыг тодорхойлох нь чухал шаардлагатай юм.

pH: Химийн урвал явагдах нь хүний биед шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд энд устөрөгчийн ион чухал үүрэгтэй. Устөрөгчийн ионы хэмжээг илэрхийлэгддэг энэ үзүүлэлт нь усны орчин болох хүчиллэг буюу шүлтлэг чанарыг заадаг.

Байгалийн усны орчин pH нь сул хүчиллэгээс сул шүлтлэг /6.5-8.5/, өөрөөр хэлбэл ихэвчлэн саармаг орчинд ойрхон байх ба энэ нь ундны усны нормтой дүйцдэг. Хэрэв усны pH 7-оос ихсэж, буурах буюу саармаг орчноос өөр орчинд шилжиж, өөрчлөлт ажиглагдаж байвал голд бохирдлын эх үүсвэр байна гэж үзэж болно. Гэвч ямар нэгэн нөлөөлөлд өртөөгүй, байгалийн төрхөөрөө байгаа зарим гол горхины усны орчин pH-ийн утга хүчиллэг, шүлтлэг байх тохиолдлууд байдаг.

ЕС буюу цахилгаан дамжуулах чанар: Усны цахилгаан дамжуулах чанар гэдэг нь цахилгаан урсгалыг зөөвөрлөх усны чадвар юм. Энэ нь усанд уссан химийн бодисуудын физик шинж чанарыг илтгэдэг. Цахилгаан дамжуулах чанар нь өндөр гарч байвал эрдэсжилт ихтэй өөрөөр хэлбэл натрийн болон хлорын ионууд зонхилж байгааг илтгэж байгаа юм.

Хатуулаг: Ундны усны чанарын бас нэг чухал шалгуур нь усны хатуулаг юм. Энэ нь усан дахь кальци, магнийн агуулагдсан хэмжээгээр илэрхийлэгдэнэ. Судлаачдын тогтоосноор хатуулгыг дараах байдлаар ангилсан байдаг. Үүнд:

- ✓ 0-1,5мг-экв/л-маш зөөлөн
- ✓ 1,51-3,0мг-экв/л-зөөлөн
- ✓ 3,1-6,0мг-экв/л-хатуувтар
- ✓ 6,1-9,0мг-экв/л-хатуу
- ✓ 9мг-экв/л-ээс их-маш хатуу гэж ангилна

Ундны усны найрлага дахь кальци, магни нь ууссан ионы хэлбэрээр байх учраас хүний биед бүрэн шингэдэг.

Усны эрдэсжилт: гэдэг нь усанд байгаа ууссан бодисын хэмжээг мг/л юмуу г/кг –аар илэрхийлсэн хэмжээ юм. Гидрохимийн практикт усанд ууссан бодисын хэмжээ

А. Гол ион тус бүрийн тоо хэмжээ г/кг юмуу мг/л -ээр далай тэнгисийн усанд г/кг –аар

Б. Ууссан хийг мг/л –ээр

В. Биогенийн элементүүдийг мг/л юмуу мкг/л –ээр ихэвчлэн далайн усанд г/мЗ –ээр эсвэл мкг/л –ээр тус тус илэрхийлнэ

4.1.2. Ундны усны чанар

Хүн амыг чанарын шаардлага хангасан ундны усаар хүрэлцээтэй хангах асуудал нь дэлхий нийтийн тулгамдсан асуудлын нэг болсоор байна. НҮБ-ын Ерөнхий ассамблейн 2003 оны XII сарын хуралдаанаас 2005-2015 оныг “Ус амьдралын эх булаг” олон улсын 10 жил болгон зарласан байдаг.

Ундны ус гэдэг нь хүн амын шууд уух болон хоол боловсруулах, ариун цэвэр, эрүүл ахуйн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор хэрэглэж байгаа чанартай аюулгүй усыг хэлнэ. Ус нь хүний физиологийн хэвийн үйл ажиллагааг хангаж, зохицуулах үүрэгтэй. Жишээ нь: Усны үндсэн найрлагыг тодорхойлох натри нь ус давсны солилцоог, кальци, магни нь зүрхний булчингийн агшилтыг зохицуулах, ясны бэхжилтэнд чухал үүрэгтэй бол гидрокарбонат нь хоол боловсруулах, хлорид, сульфат нь бодисын солилцоонд тус тус оролцдог байна.

Хүн амьдралын амин чухал үүрэг бүхий эрдэс бодис, микроэлементүүдийн 30-40%-ийг уснаас, бусдыг нь хоол хүнснээс авдаг байна. Тухайлбал төмөр, кобальт нь цус төлжүүлэх ажиллагаанд, цайр, манган нь уургийн нийлэгжилт, инсулины үүсэлтэнд, зэс, никель, молебдин нь даавар ферментүүдийн найрлагад оролцдог.

Монгол улсын хувьд MNS900:2005 гэсэн ундны усны стандартыг мөрдөн ажилладаг. Энэ стандартын гол зорилго нь хүн амын унд ахуйн усны хэрэглээнд ашиглах эрүүл ахуйн шаардлага, хэм хэмжээг хангах, түүний чанар, аюулгүй байдлын үнэлгээний үйл ажиллагааг зохицуулахад оршино.

Ундны усны байгалийн гаралтай химийн найрлагын үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Зөвшөөрөгдөх хэмжээ
1	Анзан (Мо)	мг/л	0,07
2	Бари (Ва)	мг/л	0,7
3	Бор (В)	мг/л	0,5
4	Зэс (Cu)	мг/л	1,0

5	Кальцийн ион, (Ca ²⁺)	мг/л	100,0
6	Магнийн ион, (Mg ²⁺)	мг/л	30,0
7	Манган (Mn)	мг/л	0,1
8	Натри (Na)	мг/л	200,0
9	Фосфатын ион, (PO ₄ ³⁻)	мг/л	3,5
10	Фтор (F)	мг/л	0,7-1,5
11	pH		6,5-8,5
12	Селен (Se)	мг/л	0,01
13	Стронци (Sr)	мг/л	2,0
14	Сульфатын ион, (SO ₄ ²⁻)	мг/л	500,0
15	Ерөнхий хатуулаг	мг×экв/л	7,0
16	Хлорид ион, (Cl ⁻)	мг/л	350,0
17	Хүнцэл (As)	мг/л	0,01
18	Хүхэрт устөрөгч (H ₂ S)	мг/л	0,1
19	Хром (Cr)	мг/л	0,05
20	Хуурай үлдэгдэл	мг/л	1000,0
21	Уран (U)	мг/л	0,015

4.2. Лабораторийн шинжилгээний аргачлал болон нарийвчлал

Лабораторийн ерөнхий болон хүнд металын шинжилгээг тус бүрт тохирох ICP80, IMS80T, ISE07A, ISE09V, CLA43V, ISE06T, PHY22V, SOL85V аргачлалаар хийсэн.

Шинжилгээгээр нийт 62 элемент тодорхойлсон бөгөөд лабораторийн багажийн эвдрэл гэмтлийн шалтгаанаар хлорийн шинжилгээг хийлгэх боломжгүй болсон. Шинжилгээний дүнд хлор болон гидрокарбонат, нитрат, нитрид, аммони зэрэг элементийн үр дүнг аймгийн мэргэжлийн хяналтын газраас урьд өмнө хийсэн шинжилгээний үр дүнгээс авсан.

Хүнд металын шинжилгээний үр дүнд чанарын шинжилгээг хос дээжлэлтийн аргаар лабораторийн шинжилгээг шалгах боломжтой.

Тав. Лабораторийн шинжилгээний дүн

“SGS Mongolia LLC”-лабораторид шинжлүүлсэн дээжүүдийн үр дүнг хавсралт 01 –д харуулав. Лабораторийн шинжилгээний үр дүнд боловсруулалт хийхийн өмнө чанарын шинжилгээг хийж лабораторийн шинжилгээний үр дүнгийн үнэмшлийг тодорхойлсон.

5.1. Лабораторийн шинжилгээний үр дүнд хийсэн чанарын шинжилгээ

Хэнтий аймгийн сумын төвүүдийн ундны усан хангамжийн худгуудад хийсэн лабораторийн шинжилгээний үр дүнгүүдээс ундны усны стандарт (MNS 900:2010) –д үл тохирох элементүүдийг сонгон авч график 1-ээс 8 –д харуулав. Бусад элементүүд ундны усны стандартад тохирч байна.





График 1 Эрдэсжилт



Зураг 1 Дээж авсан худгуудын газарзүйн байршлын эрдэсжилтийн тархалтын тойм зураг





График 2 Натрийн агуулга, мг/л



Зураг 2 Дээж авсан худгуудын газарзүйн байршлын Натри тархалтын тойм зураг





График 3 Магнийн агуулга, мг/л



Зураг 3 Дээж авсан худгуудын газарзүйн байршлын Магни тархалтын тойм зураг





График 4 Фторын агуулга, мг/л



Зураг 4 Дээж авсан худгуудын газарзүйн байршлын Фторын тархалтын тойм зураг





График 5 Ураны агуулга, мг/л



Зураг 5 Дээж авсан худгуудын газарзүйн байршлын Ураны тархалтын тойм зураг





График 6 Стронци агуулга, мг/л



зураг 6 Дээж авсан худгуудын газарзүйн байршлын Стронци тархалтын тойм зураг





График 4 Хатуулгийн агуулга, мг/л



зураг 4 Дээж авсан худгуудын газарзүйн байршлын Хатуулаг тархалтын тойм зураг





График 8 Кальцийн агуулга, мг/л



зураг 8 Дээж авсан худгуудын газарзүйн байршлын Кальци тархалтын тойм зураг

Зургаа. Ус хангамжийн цэгүүдийн эрүүл ахуйн өнөөгийн байдал

Хэнтий аймгийн 3 сумын нийт 10 худгийн ашиглалтын байдалтай газар дээр нь үзэж танилцахад. Дараах байдалтай байна.

- Худгуудад хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөж ажилладаггүйгээс шалтгаалан ус хангамжийн худгуудын ихэнх гэр хороолол дотор нойл, бохир усны нүх, шатахуун түгээх станц зэрэг бохирдуулагч эх үүсвэртэйгээ ойрхон
- Уст цэг буюу худгууд нь паспорт хувийн хэрэг байхгүй.
- Цэвэршүүлэх болон зөөлрүүлэх төхөөрөмжийг зааврын дагуу ашиглаагүйгээс болж эвдэрсэн
- Нэр хаягжилт байхгүй
- Сумын төвийн унд ахуйн усан хангамжийн худагт тавигдсан ус цэвэршүүлэх, зөөлрүүлэх төхөөрөмжүүдийн хүчин чадлыг тухайн худгийн хүчин чадал, сумын хүн амын тоо, усны хэрэгцээ шаардлага болон усны чанарын үзүүлэлтэнд тохируулан суурилуулаагүй зэрэг зөрчлүүд нийтлэг гарч байсан.

Ус хангамжийн худгуудыг сум тус бүрээр зураг тайлбарын хамт хавсралтаар харуулав.

Долоо. Судалгааны ажлын үр дүн

Газрын доорх усны чанарын шинжилгээний судалгааны үр дүнд тус аймгийн сумын төвүүдийн ус хангамжийн нийт 10 худгийг шинжилгээнд хамруулсан. Шинжилгээний хариуг нэгтгэн MNS0900:2005 стандарттай харьцуулахад

Газрын доорх усны чанарын шинжилгээний судалгааны үр дүнд тус аймгийн сумын төвүүдийн ус хангамжийн нийт 10 худгийг шинжилгээнд хамруулсан. Шинжилгээний хариуг нэгтгэн MNS0900:2005 стандарттай харьцуулахад

Хэнтий аймгийн Галшар сумын ЭМТ, 7-р цэцэрлэгийн худгуудад Кальци ундны усны стандартад байх хэмжээнээс илүү.

Хэнтий аймгийн Галшар сумын ЭМТ, 7-р цэцэрлэг, сумын төвийн худгуудад Магний ундны усны стандартад байх хэмжээнээс илүү.

Хэнтий аймгийн Галшар сумын ЭМТ, 7-р цэцэрлэг худгуудад Натри ундны усны стандартад байх хэмжээнээс илүү.

Хэнтий аймгийн Галшар сумын ЭМТ тус худагт Стронци ундны усны стандартад байх хэмжээнээс илүү.

Хэнтий аймгийн Галшар сумын ЭМТ, 7-р цэцэрлэг, сумын төвийн худаг, Буянт булаг, Бор-өндөр сумын цэвэр усны станц, Уурхайчдын 13-1, 49-р байр, Цээлийн худаг, Дархан сумыг Цээлийн булаг тус худгуудад Уран ундны усны стандартад байх хэмжээнээс илүү.

Хэнтий аймгийн Галшар сумын 7-р цэцэрлэг, Буянт булаг, Бор-өндөр сумын цэвэр усны станц, Уурхайчдын 13-1, 49-р байр, Цээлийн худаг, Дархан сумыг Цээлийн

булаг, ЗДТГ-ын худаг тус худгуудад Фтор ундны усны стандартад байх хэмжээнээс илүү.

Хэнтий аймгийн Галшар сумын ЭМТ, 7-р цэцэрлэгийн худгуудад Эрдэсжилт ундны усны стандартад байх хэмжээнээс илүү.

Хэнтий аймгийн Галшар сумын ЭМТ, 7-р цэцэрлэг, сумын төвийн худгуудад Хатуулаг ундны усны стандартад байх хэмжээнээс илүү.

Найм. Цаашид хэрэгжүүлэх шаардлагатай ажлын зөвлөмж

Энэхүү судалгааны үр дүнд үндэслэн дараах санал зөвлөмжүүдийг боловсруулан гаргав. Үүнд:

Унд ахуйн уст цэгийн эрүүл аюулгүй байдлыг хангах

1.1 “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам” /Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаал/-ыг мөрдөж ажиллах.

1.2. Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам /Хүнс, хөдөө, аж ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайдын 2005 оны 101/189/194 дүгээр хамтарсан тушаал/, MNS 6088:2010 “Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага”, MNS 5775:2007 “Хот суурин газрын ундны ус түгээх цэгийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага” зэрэг бичиг баримтуудыг мөрдөж ажиллах шаардлагатай байна. Эдгээр шаардлагуудыг мөрдөж ажиллаагүйгээс шалтгаалан унд ахуйн ус хангамжийн чанаргүй худгуудыг гаргуулах, ашиглалтын насжилт бага, эрүүл ахуйн бүсийн дэглэм алдагдаснаас бохирдох эрсдэл үүссэн, төвлөрсөн системд холбогдсон сумдууд газрын доорх усны нөөцийн хайгуул хийлгэхгүйгээр шууд өмнө нь ашиглаж байсан насжилт өндөртэй нөөц нь тодорхойгүй худагт шууд холбосон зэрэг зөрчлүүд илэрч байна.

Шүүлтүүрийн сонголт, түүний зохистой ашиглалтын хугацаа болон горим

Хэнтий аймгийн 3 сумын ус хангамжийн худгуудын усны чанарын шинжилгээний хариунаас харахад Магни, Кальци, Натри, Стронци, Эрдэсжилт, Хатуулаг, Фтор, Уран зэрэг элементүүд ундны усны стандарт MNS0900:2005-д зааснаар тэнцэхгүй байна. Иймд дараах шүүлтүүрүүдийг суурилуулбал зохино.

1. Фторгүйжүүлэх
2. Зөөлрүүлэх
3. Цэнгэгжүүлэх
4. Уран шүүх гэх мэт төхөөрөмжүүд болно.

Тус төрлийн шүүлтүүрүүдийг сууриллуулахдаа заавал мэргэжлийн байгууллагаар тавиулах ба ашиглалтын зааврыг чанд дагаж мөрдөх нь чухал. Мөн Шүүлтүүр суурилуулахын өмнө дахин усыг шинжилгээнд хамруулбал зохино.

Хавсралт

Хэнтий аймгийн сумын төвүүдийн унд ахуйн ус хангамжинд хэрэглэж байгаа худгуудын усны чанарын шинжилгээний дүн

			Al	Ba	Ca	Cr	Cu	Fe	K	Mg	Mn	Na
			Хөнгөнцагаан	Бари	Кальци	Хром	Зэс	Төмөр	Кали	Магни	Манган	Натри
METHOD			ICP80T	ICP80T	ICP80T	ICP80T	ICP80T	ICP80T	ICP80T	ICP80T	ICP80T	ICP80T
MNS 0900:2010			0.5	0.7	100	0.05	1	0.3	-	30	0.1	200
Сум	Уст цэг		мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л
Галшар	Буянт булаг	U-9	94	<0.01	50.6	<0.01	<0.005	<0.05	1.6	14.4	0.027	31
	Сумын төвийн худаг	U-10	<0.01	0.014	81.1	<0.01	<0.005	<0.05	2.8	40.8	0.023	95.5
	ЭМТ	U-121	<0.01	0.032	244	<0.01	<0.005	<0.05	51.6	209	1.043	513
	7-р цэцэрлэг	U-122	<0.01	0.017	178	<0.01	<0.005	<0.05	21.7	51	1.893	206
Бор-Өндөр	Цэвэр усны станц	U-13	<0.01	0.013	33.8	<0.01	<0.005	<0.05	0.9	24.3	<0.005	69
	Уурхайчдын 13-1	U-14	<0.01	0.013	33	<0.01	<0.005	<0.05	0.8	23.7	<0.005	68.2
	49-р байр	U-15	<0.01	0.011	31.3	<0.01	<0.005	<0.05	0.8	22.2	<0.005	68.4
	Цээлийн худаг	U-16	<0.01	0.02	43	<0.01	<0.005	<0.05	1	23.2	<0.005	45.4
Дархан	Цээлийн булаг худаг	U-115	<0.01	0.012	40.4	<0.01	<0.005	<0.05	0.9	21.9	<0.005	46.9
	Сумын төв ЗДТГ	U-116	<0.01	<0.01	24.2	<0.01	<0.005	<0.05	0.6	26.4	<0.005	78

		Фосфор	Стронци	Титан	Ванади	Цайр	Берилли	Скандий	Кобальт	Никель	Галли	Молибден
METHOD		ICP80T	ICP80T	ICP80T	ICP80T	ICP80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T
MNS 0900:2010		3.5	2	-	-	5	0.0002	-	-	0.02	-	0.07
Сум	Уст цэг	мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л	µG/L	мг/л	мг/л	мг/л
Галшар	Буянт булаг	<0.05	0.458	<0.01	<0.01	<0.005	0.0002	0.004	0.28	<0.0003	<0.02	0.0435
	Сумын төвийн худаг	<0.05	0.945	<0.01	3.255	<0.005	<0.0001	0.006	0.28	0.0013	<0.02	0.0082
	ЭМТ	<0.05	3.593	<0.01	<0.01	<0.005	0.0005	0.009	5.01	0.0103	<0.02	0.007
	7-р цэцэрлэг	<0.05	1.751	<0.01	<0.01	0.097	0.0019	0.006	1.49	0.0007	<0.02	0.0005
Бор-Өндөр	Цэвэр усны станц	<0.05	0.671	<0.01	<0.01	<0.005	<0.0001	0.003	0.08	<0.0003	<0.02	0.0122
	Уурхайчдын 13-1	<0.05	0.659	<0.01	<0.01	<0.005	<0.0001	0.003	0.08	<0.0003	<0.02	0.0123
	49-р байр	<0.05	0.625	<0.01	<0.01	0.021	<0.0001	0.003	0.08	<0.0003	<0.02	0.0122
	Цээлийн худаг	<0.05	0.61	<0.01	<0.01	<0.005	0.0003	0.004	0.38	<0.0003	<0.02	0.0095
Дархан	Цээлийн булаг худаг	<0.05	0.542	<0.01	<0.01	<0.005	<0.0001	0.002	<0.06	<0.0003	<0.02	0.0089
	Сумын төв ЗДТГ	<0.05	0.851	<0.01	<0.01	<0.005	<0.0001	0.002	<0.06	<0.0003	<0.02	0.0117

		As	Se	Rb	Y	Zr	Nb	Ag	Cd	In	Sn	Sb
		Хүнцэл	Селен	Рубиди	Иттри	Циркони	Ниобий	Мөнгө	Кадми	Инди	Цагаантугалга	Сурьма
METHOD		IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T
MNS 0900:2010		0.01	0.01	-	-	-	-	0.1	0.003	-	-	0.02
Сум	Уст цэг	мг/л	мг/л	µG/L	µG/L	µG/L	µG/L	мг/л	мг/л	µG/L	µG/L	мг/л
Галшар	Буянт булаг	<0.00003	<0.0002	1.53	0.07	0.16	0.11	<0.0002	0.00017	<0.001	<0.1	<0.0002
	Сумын төвийн худаг	<0.00003	<0.0002	1.09	0.011	<0.05	<0.005	<0.0002	0.00002	<0.001	<0.1	<0.0002
	ЭМТ	<0.00003	0.0005	114	0.08	27.2	4.29	0.0007	0.00049	0.001	0.2	<0.0002
	7-р цэцэрлэг	<0.00003	0.0019	62	0.055	2.64	1	<0.0002	0.00191	0.001	<0.1	<0.0002
Бор-Өндөр	Цэвэр усны станц	<0.00003	<0.0002	0.56	<0.005	<0.05	<0.005	<0.0002	0.00003	<0.001	<0.1	<0.0002
	Уурхайчдын 13-1	<0.00003	<0.0002	0.56	<0.005	<0.05	<0.005	<0.0002	0.00002	<0.001	<0.1	<0.0002
	49-р байр	<0.00003	<0.0002	0.56	<0.005	<0.05	<0.005	<0.0002	<0.00001	<0.001	<0.1	<0.0002
	Цээлийн худаг	<0.00003	0.0003	0.22	0.186	0.4	<0.005	<0.0002	0.00031	<0.001	0.3	0.0006
Дархан	Цээлийн булаг худаг	<0.00003	<0.0002	0.26	<0.005	<0.05	<0.005	<0.0002	<0.00001	<0.001	<0.1	<0.0002
	Сумын төв ЗДТГ	<0.00003	<0.0002	0.72	<0.005	<0.05	<0.005	<0.0002	<0.00001	0.001	<0.1	<0.0002

		Te	Cs	La	Ce	Pr	Nd	Sm	Eu	Gd	Tb	Dy
		Телли	Цези	Лантан	Цери	Празеоди	Неоди	Самари	Европи	Гадолини	Терби	Диспрози
	METHOD	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T
	MNS 0900:2010	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Сум	Уст цэг	µG/L	µG/L	µG/L	µG/L	µG/L	µG/L	µG/L	µG/L	µG/L	µG/L	µG/L
Галшар	Буянт булаг	<0.1	0.001	0.01	<0.05	<0.006	0.01	0.004	<0.001	0.007	<0.002	0.006
	Сумын төвийн худаг	<0.1	0.098	<0.01	<0.05	<0.006	<0.01	<0.002	0.002	<0.003	<0.002	<0.001
	ЭМТ	<0.1	5.8	<0.01	<0.05	<0.006	<0.01	<0.002	0.002	<0.003	<0.002	<0.001
	7-р цэцэрлэг	<0.1	1.28	<0.01	<0.05	<0.006	<0.01	<0.002	0.002	<0.003	<0.002	<0.001
Бор-Өндөр	Цэвэр усны станц	<0.1	0.174	<0.01	<0.05	<0.006	<0.01	<0.002	0.001	<0.003	<0.002	<0.001
	Уурхайчдын 13-1	<0.1	0.169	<0.01	<0.05	<0.006	<0.01	<0.002	0.001	<0.003	<0.002	<0.001
	49-р байр	<0.1	0.165	<0.01	<0.05	<0.006	<0.01	<0.002	<0.001	<0.003	<0.002	<0.001
	Цээлийн худаг	<0.1	0.008	0.17	<0.05	<0.006	<0.01	<0.002	0.003	<0.003	<0.002	<0.001
Дархан	Цээлийн булаг худаг	<0.1	0.007	<0.01	<0.05	<0.006	<0.01	<0.002	0.001	<0.003	<0.002	<0.001
	Сумын төв ЗДТГ	0.1	0.619	<0.01	<0.05	<0.006	<0.01	<0.002	0.001	<0.003	<0.002	<0.001

		Ho	Er	Tm	Yb	Lu	Hf	Ta	W	Hg	Tl	Pb	Bi
--	--	----	----	----	----	----	----	----	---	----	----	----	----

		Гольми	Эрби	Тулий	Иттерби	Лютиций	Гафни	Тантал	Вольфрам	Мөнгөн ус	Талли	Хартугалга	Висмут
METHOD		IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T
MNS 0900:2010		-	-	-	-	-	-	-	-	0.001	-	0.01	-
Сум	Уст цэг	µG/L	µG/L	µG/L	µG/L	µG/L	µG/L	µG/L	µG/L	мг/л	µG/L	мг/л	µG/L
Галшар	Буянт булаг	<0.001	0.004	<0.001	0.002	<0.002	<0.004	0.029	0.78	<0.0005	0.087	<0.0005	<0.01
	Сумын төвийн худаг	<0.001	<0.001	<0.001	<0.001	<0.002	<0.004	0.028	0.43	<0.0005	0.023	<0.0005	<0.01
	ЭМТ	<0.001	<0.001	0.001	0.002	<0.002	0.333	0.117	0.1	<0.0005	<0.007	<0.0005	<0.01
	7-р цэцэрлэг	<0.001	<0.001	0.001	<0.001	<0.002	0.031	0.023	<0.05	<0.0005	<0.007	<0.0005	<0.01
Бор- Өндөр	Цэвэр усны станц	<0.001	<0.001	<0.001	<0.001	<0.002	0.026	0.01	0.41	<0.0005	<0.007	<0.0005	<0.01
	Уурхайчдын 13-1	<0.001	<0.001	<0.001	<0.001	<0.002	0.022	0.011	0.45	<0.0005	<0.007	<0.0005	<0.01
	49-р байр	<0.001	<0.001	<0.001	<0.001	<0.002	0.015	0.008	0.5	<0.0005	<0.007	<0.0005	<0.01
	Цээлийн худаг	<0.001	<0.001	<0.001	<0.001	<0.002	0.006	0.007	1	<0.0005	<0.007	<0.0005	<0.01
Дархан	Цээлийн булаг худаг	<0.001	<0.001	<0.001	0.001	<0.002	<0.004	<0.001	0.15	<0.0005	<0.007	<0.0005	<0.01
	Сумын төв ЗДТГ	<0.001	<0.001	<0.001	0.001	<0.002	0.004	<0.001	0.15	<0.0005	<0.007	<0.0005	<0.01

		Th	U	F	Cond	SO4_S	pH	TDS		CN-Free
--	--	----	---	---	------	-------	----	-----	--	---------

		Торий	Уран	Фтор	Цахилгаан дамжуулах	Сульфат		Эрдэсжилт	Хатуулаг	Чөлөөт цианид
METHOD		IMS80T	IMS80T	ISE07A	ISE09V	CLA43V	ISE06T	PHY22V		SOL85V
MNS 0900:2010		-	0.015	0.7-1.5	-	500	6.5-8.5	1000	7	0.01
Сум	Уст цэг	µG/L	мг/л	мг/л	µS/CM	мг/л	NOUNIT	мг/л	мг-экв/л	мг/л
Галшар	Буянт булаг	<0.002	0.0236	1.6	554	90	6.9	328	3.71	<0.001
	Сумын төвийн худаг	<0.002	0.0587	1.5	1137	120	7.6	460	7.40	<0.001
	ЭМГ	0.037	0.513	0.95	4400	129	6.6	2860	29.36	<0.001
	7-р цэцэрлэг	<0.002	0.0476	1.6	2050	82	7.7	1260	13.08	<0.001
Бор-Өндөр	Цэвэр усны станц	<0.002	0.0156	2.5	701	100	8.18	362	3.68	<0.001
	Уурхайчдын 13- 1	<0.002	0.016	2.5	700	90	8	344	3.60	<0.001
	49-р байр	<0.002	0.0155	2.6	707	90	8.2	360	3.39	<0.001
	Цээлийн худаг	<0.002	0.0162	2.1	621	70	8.2	322	4.05	<0.001
Дархан	Цээлийн булаг худаг	<0.002	0.0167	2.2	602	56	7.8	352	3.82	<0.001
	Сумын төв ЗДТГ	<0.002	18.2	2.9	718	75	8	408	3.38	<0.001

Хэнтий аймгийн сумын төвүүдийн унд ахуйн усны чанарын шинжилгээ авсан худгуудын зураг:

Бор-Өндөр сум, УБУ, Цэвэр усны станц	Бор-Өндөр сум, УБУ, 1-р худаг
 Бор-Өндөр сум, Ус түгээх байр	1.Эзэмшигч: Бор-өндөр 2.Усны түвшин, худгийн гүн: 3.Худгийн төрөл: Ус түгээх 4.Зориулалт: Унд ахуй 5.Эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоох боломжтой эсэх: Үгүй 6.Физик, химийн үзүүлэлт: Цахилгаан дамжуулах: 0,5 PH:7,6 Температур: 14,6 TDS: 0,29 7.Хашаагаар хамгаалсан эсэх: Үгүй 8.Худгийн орчимд бохирдуулагч байгаа эсэх: Тийм,
 Галшар сум, Цагаан худаг	1.Эзэмшигч: ЗДТГ 2.Усны түвшин, худгийн гүн: 3.Худгийн төрөл: Ө.Х 1970 он 4.Зориулалт: Унд ахуй 5.Эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоох боломжтой эсэх: Үгүй 6.Физик, химийн үзүүлэлт: Цахилгаан дамжуулах: 0,73 PH:6,9 Температур: 7,6 TDS: 0,4 7.Хашаагаар хамгаалсан эсэх: Тийм 8.Худгийн орчимд бохирдуулагч байгаа эсэх: Үгүй 10.Хичнээн хүнд ус түгээдэг: 100 хүн
 Галшар сум, Цэцэрлэг	1.Эзэмшигч: 2.Усны түвшин, худгийн гүн: 3.Худгийн төрөл: 4.Зориулалт: 5.Эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоох боломжтой эсэх: 6.Физик, химийн үзүүлэлт: Цахилгаан дамжуулах: PH: Температур: TDS: 7.Худгийн доторлогоо: 8.Хашаагаар хамгаалсан эсэх: 9.Худгийн орчимд бохирдуулагч байгаа эсэх: Тийм 10. Хичнээн хүнд ус түгээдэг:

	1.Эзэмшигч: ЗДТГ 2.Усны түвшин, худгийн гүн: 90 м 3.Худгийн төрөл: Булаг 4.Зориулалт: Унд ахуй 5.Эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоох боломжтой эсэх: Тийм 6.Физик, химийн үзүүлэлт: Цахилгаан дамжуулах: 0,29 PH:7,75 Температур: 5,6 TDS: 0,17 7.Хашаагаар хамгаалсан эсэх: Тийм 8.Худгийн орчимд бохирдуулагч байгаа эсэх: Үгүй 9. Хичнээн хүн үс авдаг: 350 хүн
	1.Эзэмшигч: 2.Усны түвшин, худгийн гүн: 3.Худгийн төрөл: 4.Зориулалт: 5.Эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоох боломжтой эсэх: 6.Физик, химийн үзүүлэлт: Цахилгаан дамжуулах: PH: Температур: TDS: 7.Худгийн доторлогоо: 8.Хашаагаар хамгаалсан эсэх: 9.Худгийн орчимд бохирдуулагч байгаа эсэх: 10. Хичнээн хүнд үс түгээдэг:
	1.Эзэмшигч: Бор-Өндөр УБҮ 2.Усны түвшин, худгийн гүн: 90 м 3.Худгийн төрөл: Ө.Х 4.Зориулалт: Унд ахуй 5.Эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоох боломжтой эсэх: Үгүй 6.Физик, химийн үзүүлэлт: Цахилгаан дамжуулах: 0,34 PH:7,88 Температур: 6,9 TDS: 0,2 7.Хашаагаар хамгаалсан эсэх: Тийм 8.Худгийн орчимд бохирдуулагч байгаа эсэх: Тийм 10. Хичнээн хүнд үс түгээдэг: 3500 хүн

Галшар сум, Буянт булаг

Галшар сум, Эмнэлэг

Дархан сум, Сумын төвийн худаг

Хэнтий аймгийн сумын төвүүдийн унд

			Al	Ba
			Хөнгөнцагаан	Бари
METHOD			ICP80T	ICP80T
MNS 0900:2010			0.5	0.7
Сум	Уст цэг		мг/л	мг/л
Галшар	Буянт булаг	U-9	94	<0.01
	Сумын төвийн худаг	U-10	<0.01	0.014
	ЭМТ	U-121	<0.01	0.032
	7-р цэцэрлэг	U-122	<0.01	0.017
Бор-Өндөр	Цэвэр усны станц	U-13	<0.01	0.013
	Уурхайчдын 13-1	U-14	<0.01	0.013
	49-р байр	U-15	<0.01	0.011
	Цээлийн худаг	U-16	<0.01	0.02
Дархан	Цээлийн булаг худаг	U-115	<0.01	0.012
	Сумын төв ЗДТГ	U-116	<0.01	<0.01

д ахуйн ус хангамжинд хэрэглэж байгаа худгуудын усны чанарын шинжилгээний дүн

Ca	Cr	Cu	Fe	K	Mg	Mn	Na	P
Кальци	Хром	Зэс	Төмөр	Кали	Магни	Манган	Натри	Фосфор
ICP80T	ICP80T	ICP80T	ICP80T	ICP80T	ICP80T	ICP80T	ICP80T	ICP80T
100	0.05	1	0.3	-	30	0.1	200	3.5
мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л
50.6	<0.01	<0.005	<0.05	1.6	14.4	0.027	31	<0.05
81.1	<0.01	<0.005	<0.05	2.8	40.8	0.023	95.5	<0.05
244	<0.01	<0.005	<0.05	51.6	209	1.043	513	<0.05
178	<0.01	<0.005	<0.05	21.7	51	1.893	206	<0.05
33.8	<0.01	<0.005	<0.05	0.9	24.3	<0.005	69	<0.05
33	<0.01	<0.005	<0.05	0.8	23.7	<0.005	68.2	<0.05
31.3	<0.01	<0.005	<0.05	0.8	22.2	<0.005	68.4	<0.05
43	<0.01	<0.005	<0.05	1	23.2	<0.005	45.4	<0.05
40.4	<0.01	<0.005	<0.05	0.9	21.9	<0.005	46.9	<0.05
24.2	<0.01	<0.005	<0.05	0.6	26.4	<0.005	78	<0.05

Sr	Ti	V	Zn	Be	Sc	Co	Ni	Ga
Стронци	Титан	Ванади	Цайр	Берилли	Скандий	Кобальт	Никель	Галли
ICP80T	ICP80T	ICP80T	ICP80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T
2	-	-	5	0.0002	-	-	0.02	-
мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л	μG/L	мг/л	мг/л
0.458	<0.01	<0.01	<0.005	0.0002	0.004	0.28	<0.0003	<0.02
0.945	<0.01	3.255	<0.005	<0.0001	0.006	0.28	0.0013	<0.02
3.593	<0.01	<0.01	<0.005	0.0005	0.009	5.01	0.0103	<0.02
1.751	<0.01	<0.01	0.097	0.0019	0.006	1.49	0.0007	<0.02
0.671	<0.01	<0.01	<0.005	<0.0001	0.003	0.08	<0.0003	<0.02
0.659	<0.01	<0.01	<0.005	<0.0001	0.003	0.08	<0.0003	<0.02
0.625	<0.01	<0.01	0.021	<0.0001	0.003	0.08	<0.0003	<0.02
0.61	<0.01	<0.01	<0.005	0.0003	0.004	0.38	<0.0003	<0.02
0.542	<0.01	<0.01	<0.005	<0.0001	0.002	<0.06	<0.0003	<0.02
0.851	<0.01	<0.01	<0.005	<0.0001	0.002	<0.06	<0.0003	<0.02

Mo	As	Se	Rb	Y	Zr	Nb	Ag	Cd
Молибден	Хүнцэл	Селен	Рубиди	Иттри	Циркони	Ниобий	Мөнгө	Кадми
IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T
0.07	0.01	0.01	-	-	-	-	0.1	0.003
мг/л	мг/л	мг/л	µG/L	µG/L	µG/L	µG/L	мг/л	мг/л
0.0435	<0.00003	<0.0002	1.53	0.07	0.16	0.11	<0.0002	0.00017
0.0082	<0.00003	<0.0002	1.09	0.011	<0.05	<0.005	<0.0002	0.00002
0.007	<0.00003	0.0005	114	0.08	27.2	4.29	0.0007	0.00049
0.0005	<0.00003	0.0019	62	0.055	2.64	1	<0.0002	0.00191
0.0122	<0.00003	<0.0002	0.56	<0.005	<0.05	<0.005	<0.0002	0.00003
0.0123	<0.00003	<0.0002	0.56	<0.005	<0.05	<0.005	<0.0002	0.00002
0.0122	<0.00003	<0.0002	0.56	<0.005	<0.05	<0.005	<0.0002	<0.00001
0.0095	<0.00003	0.0003	0.22	0.186	0.4	<0.005	<0.0002	0.00031
0.0089	<0.00003	<0.0002	0.26	<0.005	<0.05	<0.005	<0.0002	<0.00001
0.0117	<0.00003	<0.0002	0.72	<0.005	<0.05	<0.005	<0.0002	<0.00001

In	Sn	Sb	Te	Cs	La	Ce	Pr	Nd
Инди	Цагаантуг	Сурьма	Телли	Цези	Лантан	Цери	Празеоди	Неоди
IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T
-	-	0.02	-	-	-	-	-	-
μG/L	μG/L	мг/л	μG/L	μG/L	μG/L	μG/L	μG/L	μG/L
<0.001	<0.1	<0.0002	<0.1	0.001	0.01	<0.05	<0.006	0.01
<0.001	<0.1	<0.0002	<0.1	0.098	<0.01	<0.05	<0.006	<0.01
0.001	0.2	<0.0002	<0.1	5.8	<0.01	<0.05	<0.006	<0.01
0.001	<0.1	<0.0002	<0.1	1.28	<0.01	<0.05	<0.006	<0.01
<0.001	<0.1	<0.0002	<0.1	0.174	<0.01	<0.05	<0.006	<0.01
<0.001	<0.1	<0.0002	<0.1	0.169	<0.01	<0.05	<0.006	<0.01
<0.001	<0.1	<0.0002	<0.1	0.165	<0.01	<0.05	<0.006	<0.01
<0.001	0.3	0.0006	<0.1	0.008	0.17	<0.05	<0.006	<0.01
<0.001	<0.1	<0.0002	<0.1	0.007	<0.01	<0.05	<0.006	<0.01
0.001	<0.1	<0.0002	0.1	0.619	<0.01	<0.05	<0.006	<0.01


Sm	Eu	Gd	Tb	Dy	Ho	Er	Tm	Yb
Самари	Европи	Гадолини	Терби	Диспрози	Гольми	Эрби	Тулий	Иттерби
IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T
-	-	-	-	-	-	-	-	-
μG/L	μG/L	μG/L	μG/L	μG/L	μG/L	μG/L	μG/L	μG/L
0.004	<0.001	0.007	<0.002	0.006	<0.001	0.004	<0.001	0.002
<0.002	0.002	<0.003	<0.002	<0.001	<0.001	<0.001	<0.001	<0.001
<0.002	0.002	<0.003	<0.002	<0.001	<0.001	<0.001	0.001	0.002
<0.002	0.002	<0.003	<0.002	<0.001	<0.001	<0.001	0.001	<0.001
<0.002	0.001	<0.003	<0.002	<0.001	<0.001	<0.001	<0.001	<0.001
<0.002	0.001	<0.003	<0.002	<0.001	<0.001	<0.001	<0.001	<0.001
<0.002	<0.001	<0.003	<0.002	<0.001	<0.001	<0.001	<0.001	<0.001
<0.002	0.003	<0.003	<0.002	<0.001	<0.001	<0.001	<0.001	<0.001
<0.002	0.001	<0.003	<0.002	<0.001	<0.001	<0.001	<0.001	0.001
<0.002	0.001	<0.003	<0.002	<0.001	<0.001	<0.001	<0.001	0.001

Lu	Hf	Ta	W	Hg	Tl	Pb	Bi	Th
Лютиций	Гафни	Тантал	Вольфрам	Мөнгөн	Талли	Хартугалг	Висмут	Торий
IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T	IMS80T
-	-	-	-	0.001	-	0.01	-	-
µG/L	µG/L	µG/L	µG/L	мг/л	µG/L	мг/л	µG/L	µG/L
<0.002	<0.004	0.029	0.78	<0.0005	0.087	<0.0005	<0.01	<0.002
<0.002	<0.004	0.028	0.43	<0.0005	0.023	<0.0005	<0.01	<0.002
<0.002	0.333	0.117	0.1	<0.0005	<0.007	<0.0005	<0.01	0.037
<0.002	0.031	0.023	<0.05	<0.0005	<0.007	<0.0005	<0.01	<0.002
<0.002	0.026	0.01	0.41	<0.0005	<0.007	<0.0005	<0.01	<0.002
<0.002	0.022	0.011	0.45	<0.0005	<0.007	<0.0005	<0.01	<0.002
<0.002	0.015	0.008	0.5	<0.0005	<0.007	<0.0005	<0.01	<0.002
<0.002	0.006	0.007	1	<0.0005	<0.007	<0.0005	<0.01	<0.002
<0.002	<0.004	<0.001	0.15	<0.0005	<0.007	<0.0005	<0.01	<0.002
<0.002	0.004	<0.001	0.15	<0.0005	<0.007	<0.0005	<0.01	<0.002



U	F	Cond	SO4 S	pH	TDS		CN-Free
Уран	Фтор	Цахилгаан	Сульфат		Эрдэсжилт	Хатуулаг	Чөлөөт
IMS80T	ISE07A	ISE09V	CLA43V	ISE06T	PHY22V		SOL85V
0.015	0.7-1.5	-	500	6.5-8.5	1000	7	0.01
мг/л	мг/л	μS/CM	мг/л	NOUNIT	мг/л	мг-экв/л	мг/л
0.0236	1.6	554	90	6.9	328	3.71	<0.001
0.0587	1.5	1137	120	7.6	460	7.40	<0.001
0.513	0.95	4400	129	6.6	2860	29.36	<0.001
0.0476	1.6	2050	82	7.7	1260	13.08	<0.001
0.0156	2.5	701	100	8.18	362	3.68	<0.001
0.016	2.5	700	90	8	344	3.60	<0.001
0.0155	2.6	707	90	8.2	360	3.39	<0.001
0.0162	2.1	621	70	8.2	322	4.05	<0.001
0.0167	2.2	602	56	7.8	352	3.82	<0.001
18.2	2.9	718	75	8	408	3.38	<0.001

3.71
7.4
29.36
13.08
3.68
3.6
3.39
4.05
3.82
3.38

		Кали	Стандарт	К	Mg	Na	U
			MNS 0900:200	Кали	Магни	Натри	Уран
Галшар	Буянт булаг	1.6	7	1.6	14.4	31	0.0236
	Сумын төвийн худаг	2.8	7	2.8	40.8	95.5	0.0587
	ЭМТ	51.6	7	51.6	209	5	
	7-р цэцэрлэг	21.7	7	21.7	51	2	
Бор-Өндөр	Цэвэр усны станц	0.9	7	0.9	24.3		
	Уурхайчдын 13-1	0.8	7	0.8	23.7	68	
	49-р байр	0.8	7	0.8	22.2	68	
	Цээлийн худаг	1	7	1	23.2	45	
Дархан	Цээлийн булаг худаг	0.9	7	0.9	21.9	40	
	Сумын төв ЗДТГ	0.6	7	0.6	26.4		
0900:2010		100		-	30	200	



F	SO4_S	pH	TDS		Sr
Фтор	Сульфат		Эрдэсжилт	Хатуулаг	Стронци
1.6	90	6.9	328	1.26	0.458
1.5	120	7.6	460	3.49	0.945



Хатуулаг

